

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Ой ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/48/НА/-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас:70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Ц.Аззаяа

Утас: 70432545

цахим хаяг: azzayats@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт.....	12
4.1 Залруулсан алдаа.....	13
4.2 Зөвлөмж	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН ДАРГА
Ц.ДАВААХҮҮ ТАНАА

2022.02.25 № 2/
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Сум дундын ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Сум дундын ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,682,755.0</u>	<u>7,682,755.0</u>
33	АВЛАГА	1,895,335.0	1,895,335.0
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,895,335.0	1,895,335.0
35	БАРАА МАТЕРИАЛ	5,787,420.0	5,787,420.0
354	Хангамжийн материал	1,847,320.0	1,847,320.0
35420	Аж ахуйн материал	1,847,320.0	1,847,320.0
35500	Биологийн хөрөнгө	3,940,100.0	3,940,100.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>35,767,711.2</u>	<u>25,772,887.9</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	35,767,711.2	25,772,887.9
392	Биет хөрөнгө	35,492,711.0	25,662,887.7
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,927,800.0	1,927,800.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	(642,600.0)	(963,900.0)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	64,130,520.0	64,130,520.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(38,380,520.0)	(45,817,858.1)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	39,163,323.3	33,872,039.3
39206	Хуримтлагдсан элэгдэл	(30,889,980.4)	(27,539,881.7)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,300,000.0	1,300,000.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,115,831.8)	(1,245,831.7)
393	Биет бус хөрөнгө	275,000.1	110,000.1
39301	Програм хангамж	880,000.0	880,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(604,999.9)	(769,999.9)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>43,450,466.2</u>	<u>33,455,642.9</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>1,294,894.0</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,294,894.0
413	Өглөг	-	1,294,894.0
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,294,894.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>43,448,932.1</u>	<u>32,159,214.8</u>

51	Засгийн газрын хувь оролцоо	43,448,932.1	32,159,214.8
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	150,000.0	150,000.0
51101	Өмч: - төрийн	150,000.0	150,000.0
512	Хуримтлагдсан үр дүн	43,298,932.1	32,009,214.8
51210	Өмнөх үеийн үр дүн	43,298,932.1	43,298,932.1
51220	Тайлант үеийн үр дүн	-	(11,289,717.3)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	43,448,932.1	33,454,108.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	56,398,138.0	55,118,891.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,491,428.0	3,056,500.0
120	Нийтлэг татварын бус орлого	1,491,428.0	3,056,500.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,491,428.0	3,056,500.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,491,428.0	3,056,500.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	54,906,710.0	52,062,391.9
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	(337,108.1)
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	(337,108.1)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,820,200.0	290,000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,820,200.0	290,000.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	53,086,510.0	52,109,500.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	53,086,510.0	52,109,500.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	67,290,812.8	66,408,609.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	67,290,812.8	66,408,609.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	66,589,860.6	66,408,609.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	41,699,727.9	43,997,585.9
210101	Үндсэн цалин	31,906,716.2	34,842,893.9
210102	Нэмэгдэл	8,067,504.0	7,447,883.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,725,507.7	1,706,808.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,422,275.0	5,061,100.0

210201	Тэтгэврийн даатгал	3,876,412.7	3,561,500.0
210202	Тэтгэмжийн даатгал	382,261.4	374,900.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	310,300.4	299,900.0
210204	Ажилгүйдлийн даатгал	77,600.0	75,000.0
210205	Эрүүл мэндийн даатгал	775,700.5	749,800.0
2104	Хангамж, бараа материалын зардал	6,432,190.0	4,594,400.0
210401	Бичиг хэрэг	291,600.0	269,700.0
210402	Тээвэр, шатахуун	3,136,950.0	3,975,520.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	347,440.0	349,180.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,656,200.0	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	92,500.0	576,700.0
210604	Урсгал засвар	92,500.0	576,700.0
2107	Томилолт, зочны зардал	376,000.0	2,000,500.0
210702	Дотоод албан томилолт	376,000.0	2,000,500.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,449,678.0	183,500.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	846,500.0	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	262,000.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	184,500.0	79,500.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	121,500.0	79,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	35,178.0	25,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,117,489.7	9,994,823.3
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,466,489.7	9,994,823.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	700,952.2	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	700,000.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.0	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	952.2	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	952.2	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(10,892,674.8)	(11,289,717.3)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(10,892,674.8)	(11,289,717.3)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	150,000.0	43,298,932.1	43,448,932.1
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	150,000.0	43,298,932.1	43,448,932.1
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	150,000.0	43,298,932.1	43,448,932.1
D08	Тайлант үеийн үр дүн	-	(11,289,717.3)	(11,289,717.3)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	150,000.0	32,009,214.8	32,159,214.8

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	56,398,138.0	55,118,891.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,491,428.0	3,056,500.0
120	Нийтлэг татварын бус орлого	1,491,428.0	3,056,500.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,491,428.0	3,056,500.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,491,428.0	3,056,500.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	54,906,710.0	52,062,391.9
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	(337,108.1)
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	(337,108.1)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,820,200.0	290,000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,820,200.0	290,000.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	53,086,510.0	52,109,500.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	53,086,510.0	52,109,500.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	56,398,129.0	55,118,891.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	56,398,129.0	55,118,891.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	55,547,176.8	55,118,891.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	37,610,002.7	37,661,391.9
210101	Үндсэн цалин	27,816,991.0	28,506,699.9
210102	Нэмэгдэл	8,067,504.0	7,447,883.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,725,507.7	1,706,808.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,827,106.1	5,061,100.0

210201	Тэтгэврийн даатгал	3,281,245.0	3,561,500.0
210202	Тэтгэмжийн даатгал	382,261.1	374,900.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	310,300.0	299,900.0
210204	Ажилгүйдлийн даатгал	77,600.0	75,000.0
210205	Эрүүл мэндийн даатгал	775,700.0	749,800.0
2104	Хангамж, бараа материалын зардал	5,787,190.0	4,594,400.0
210401	Бичиг хэрэг	264,880.0	269,700.0
210402	Тээвэр, шатахуун	3,136,950.0	3,975,520.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	336,660.0	349,180.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,048,700.0	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	92,500.0	576,700.0
210604	Урсгал засвар	92,500.0	576,700.0
2107	Томилолт, зочны зардал	376,000.0	2,000,500.0
210702	Дотоод албан томилолт	376,000.0	2,000,500.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,910,878.0	5,224,800.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,307,700.0	5,041,300.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	262,000.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	179,500.0	79,500.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	121,500.0	79,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,178.0	25,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	943,500.0	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	943,500.0	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	850,952.2	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	850,000.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	850,000.0	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	952.2	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	952.2	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	55,092,500.0	54,828,891.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	55,092,500.0	54,828,891.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	54,592,500.0	54,828,891.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	35,736,400.0	37,481,391.9
210101	Үндсэн цалин	26,574,100.0	28,326,699.9
210102	Нэмэгдэл	7,429,800.0	7,447,883.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,732,500.0	1,706,808.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,824,500.0	5,061,100.0
210201	Тэтгэврийн даатгал	3,395,000.0	3,561,500.0
210202	Тэтгэмжийн даатгал	357,400.0	374,900.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	285,900.0	299,900.0
210204	Ажилгүйдлийн даатгал	71,500.0	75,000.0
210205	Эрүүл мэндийн даатгал	714,700.0	749,800.0
2104	Хангамж, бараа материалын зардал	5,125,100.0	4,594,400.0
210401	Бичиг хэрэг	270,700.0	269,700.0
210402	Тээвэр, шатахуун	3,975,800.0	3,975,520.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	598,100.0	349,180.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	280,500.0	-
2105	Нормативт зардал	333,300.0	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	333,300.0	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	466,700.0	466,700.0
210604	Урсгал засвар	466,700.0	466,700.0
2107	Томилолт, зочны зардал	2,283,300.0	2,000,500.0
210702	Дотоод албан томилолт	2,283,300.0	2,000,500.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,823,200.0	5,224,800.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,500,000.0	5,041,300.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.0	-

210803	Даатгалын үйлчилгээ	116,700.0	79,500.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	81,500.0	79,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.0	25,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.0	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.0	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	55,092,500.0	54,828,891.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	52,092,500.0	51,772,391.9
132001	Орон нутгийн төсвөөс	52,092,500.0	51,772,391.9
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,000,000.0	3,056,500.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000.0	3,056,500.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,346,500.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,346,500.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,346,500.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	180,000.0
210101	Үндсэн цалин	180,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	110,000.0
210604	Урсгал засвар	110,000.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,346,500.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,346,500.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,346,500.0
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Ой ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Ц.Аззаяа 2022 оны 01 дүгээр сарын 24-нээс 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ховд аймгийн Ойн анги нь “Ойн тухай хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэх, ойн санг хамгаалах ажлыг удирдан зохион байгуулах, ойн хортон, түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, ойн мэдээллийн санг бүрдүүлэх, ойн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх мод бут тарих арчилж ургуулах талаар сургалт сурталчилгаа зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, ойжуулалтын ажлыг гүйцэтгэх, ой хамгаалах иргэдийн нөхөрлөлийн ажилд дэмжлэг үзүүлэх гэж үндсэн зорилго тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар 2019-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлэн иж бүрэн хяналт шалгалтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлын тайланг аудитад ашиглалаа.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны нийт зардлын 66.4 сая төгрөгөөс 2.0 хувиар тооцон 1.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 1.1 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ховд аймгийн Ой ангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10.0 сая төгрөгөөр буюу 21.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Өмнөх оны төлбөртэй үйлчилгээний 1.9 сая төгрөгийн авлага барагдаагүй байна..

Бараа материалын дансны үлдэгдэл 5.8 сая төгрөг байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 4.3 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үйл ажиллагаандаа 4.3 сая төгрөгийн материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 35.8 сая төгрөг, оны эцэст 25.8 сая төгрөг болж 10.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардалтай холбоотой байна.

Тайлант онд өр төлбөр 1.3 сая төгрөг болж 1.3 сая төгрөгөөр өссөн нь татварт төлөх өглөг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 43.4 сая төгрөг байсан ба оны эцэст 32.1 сая төгрөг болж өөрчлөгдсөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 32.1 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Ховд аймгийн Ховд аймгийн Ой ангийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 52.0 сая төгрөгөөр, өөрийн орлогоор 3.0 сая, нийт зарлагыг 55.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 55.0 мянган төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 55.0 сая төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 52.0 сая төгрөгийг, өөрийн орлогоор 3.0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 51.8 сая төгрөгийн, өөрийн орлогоор 3.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 54.8 сая төгрөгийг зарцуулж, 0.3 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 54.8 сая төгрөг буюу 96 хувьтай байгаа нь цалин хангамж бараа материалын зардлыг 0.5 сая төгрөгөөр, албан томилолтын зардлыг 0.3 сая

төгрөгөөр, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 0.6 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны байгууллагаас 3.3 сая төгрөгийн санхүүжилтийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн дээрх эх үүсвэрүүдийг холбогдох арга хэмжээнд зарцуулжээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 146 хугацаандаа оруулсан 4 мэдээлэл хугацаа болоогүй, тухай бүр шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 0.8 сая төгрөгийн 2 зөвлөмж, 0.2 сая төгрөгийн 2 төлбөрийн акт бичигдсэнийг бүрэн биелүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас тус байгууллагын 2019-2021 оны үйл ажиллагааны үр дүнд аудит хийж 3 зөвлөмж, 1 төлбөрийн акт тогтоосон байх тул алдаа зөрчилтэй асуудлыг давхцуулах шаардлагагүй гэж үзсэн болно.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулсан алдаа байхгүй болно.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая. төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ховд аймгийн Ой анги	-	-	-	-	-	-	-	-	-	-

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР